

АЖЛЫН ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ ГЭРЭЭ

Дугаар № 127/2022

20²² оны 11-р сарын 03

Улаанбаатар хот

Энэхүү ажил гүйцэтгэх гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г нэг талаас “Амгалан дулааны станц” ТӨХК /РД:6021646/ -ийг төлөөлж Гүйцэтгэх захирал М.Мөнхөө (цаашид “Захиалагч” гэх), нөгөө талаас Иргэн Б.Сарантуяа /РД:НО70062181/ (цаашид “Гүйцэтгэгч” гэх) нар (хамтад нь “Талууд” гэх) нар Монгол Улсын Иргэний хуулийн 343-358 дугаар зүйл, Монгол Улсын Эрчим хүчний сайдын 2022 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн А/104 дүгээр тушаалыг үндэслэл болгож дараах нөхцлөөр тохиролцож байгуулав.

Нэг. Гэрээний зорилго

- 1.1 Энэхүү гэрээний зорилго нь Гүйцэтгэгч талаас Захиалагчийн “Амгалан дулааны станц” ТӨХК-ийн зуухны экран хоолой болон барилгын засварын ажлын төсөв боловсруулах” ажлыг энэхүү гэрээний салшгүй хэсэг болох хавсралтад заасан ажлын жагсаалтыг гэрээнд заагдсан хугацаанд Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, норм дүрэм, чанарын стандартын шаардлагын дагуу гүйцэтгэх, Захиалагч нь гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэлийг дүгнэж зохих шаардлагыг хангасан гэж үзвэл энэхүү гэрээгээр тохиролцсон хугацаанд ажлын хөлсийг төлөх, харилцан үүрэг хүлээх, хариуцлагыг тогтоох, ажил эхлэх, гүйцэтгэх, дуусах явцтай холбоотой үүссэн харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Гэрээний үнэ, төлбөрийн нөхцөл

- 2.1 Энэхүү гэрээт ажлын үнэ нь **14,800,000** /Арван дөрвөн сая найман зуун мянга/ төгрөг байхаар талууд харилцан тохиролцов. Энэ нь НӨАТ мөн татвар даатгалтай холбоотой бүх зардлууд багтсан болно.
- 2.2 Урьдчилгаа төлбөр **2,000,000** /хоёр сая/ төгрөг.
- 2.3 Гэрээт ажлын үлдэгдэл төлбөрийг гүйцэтгэсэн ажлын тайлан дүгнэлт болон бусад баримт бичиг, гэрээ дүгнэсэн актыг үндэслэн нэхэмжлэлийн дагуу гүйцэтгэгчийн Хаан банкны **5037235548** тоот дансанд 30 хоногийн дотор шилжүүлнэ.

Гурав. Гэрээний хугацаа

- 3.1 Гүйцэтгэгч гэрээт ажлыг 2022 оны 11 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн 11 дүгээр сарын 23-ны дотор 20 /хорь/ хоногт багтаан гүйцэтгэж дуусгана.

Дөрөв. Талуудын эрх, үүрэг

- 4.1 Захиалагч нь дараах эрхийг эдэлж, үүрэг хүлээнэ. Үүнд:
- 4.1.1 Гүйцэтгэгчийн энэхүү Гэрээний дагуу гүйцэтгэж буй ажил, үйлчилгээг гэрээгээр тогтоосон хугацаанд хэрэгжүүлэхийг шаардах;
- 4.1.2 Захиалагч ажлын гүйцэтгэл, явц, үр дүнгийн талаар тогтмол, тайлан мэдээг тухай бүр гүйцэтгэгчээс авах;